## ГАРЧИГ

### БҮЛЭГ 1.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..........3-4

2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН .......... 5-7

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........8-21

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........22-26

5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........27-28

6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ,НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........29

7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........29

8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........30-35

9. ХОГ,ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........36-40

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ..........41-44

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........45-50

12. ДҮГНЭЛТ..........51

## ОРШИЛ

“Од” нэртэй MV-020628 дугаартай тусгай зөвшөөрлийн талбай нь Завхан аймгийн Ургамал сумын нутагт, байр зүйн зургийн М-46-128 дугаартай хавтгайд байрлана.

MV-020628 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газар нь 1639.24 га эзэлдэг бөгөөд талбай нь ерөнхийдөө урдаас хойш 4.9 км, баруунаас зүүн тийш 5.1 км хэмжээтэй.

MV-020628 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай хайгуул явуулсан талбай нь засаг захиргааны хувьд Завхан аймгийн Ургамал сумын нутагт хамаарна. Ургамал сумын төвөөс баруун урагш 27 км, Улаанбаатар хотоос баруун хойш 1250 гаруй км, Завхан аймгийн төвөөс БХ 226 орчим км зайд байдаг.

Байгаль орчны менежементийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагавар хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“Форсголд Майнинг” ХХК-ийн төслийн Байгаль орчны менежментийн тайланг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, төслийн газар дээр хийгдсэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, шинжилгээний дүн, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2019-10-29-ны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах”журам” зэрэг эрх зүйн баримт, материалуудыг үндэс болгон боловсруулав.

Энэхүү тайлангаар төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежементийн төлөвлөгөөтэй нь нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

*ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА*

## Төслийн товч тодорхойлолт

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл*

| **Төслийн нэр:** | **төсөл** |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, 7-р хороолол, Шинэ дэлхий телевизийн байр 803 тоот. Утас:77100909 |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9011622079 |
| Регистрийн дугаар: | 6088759 |
| Төсөл хэрэгжих газрын байршил: | Завхан аймгийн Ургамал сумын нутагт, байр зүйн зургийн М-46-128 дугаартай хавтгайд байрлана. |

Төсөл хэрэгжүүлэгч “Форсголд Майнинг”ХХК нь уг төсөл Ашигт малтмал,газрын тосны газраас MV-020628 дугаартай тусгай зөвшөөрлийг Завхан аймгийн Ургамал сум Од нэртэй газарт 1639.24 гектар газарт хэрэгжүүлэхээр авч үйл ажиллагаа явуулж байна.

*Зураг-1.Төслийн талбайн байршлын зураг*




*Хүснэгт 2. Координат солбилцолын цэгүүд*

| Талбайн булангийн цэгүүд | Өргөрөг | Уртраг |
|---|---|---|
| 1 | 93° 59’50.00” | 48° 24’20.40” |
| 2 | 93° 59’ 50.00” | 48° 21’30.30” |
| 3 | 93° 59’ 42.60” | 48° 21’ 30.30” |
| 4 | 93° 59’ 39.30” | 48° 21’ 37.30” |
| 5 | 93° 59’ 34.84” | 48° 21’ 37.24” |
| 6 | 93° 57’ 30.00” | 48° 21’ 37.24” |
| 7 | 93° 57’ 30.00” | 48° 23’ 30.00” |
| 8 | 93° 56’ 30.00” | 48° 23’ 30.00” |
| 9 | 93° 56’ 30.00” | 48° 24’ 14.60” |
| 10 | 93° 56’ 44.80” | 48° 24’ 14.60” |
| 11 | 93° 56’ 50.50” | 48° 24’ 15.00” |
| 12 | 93° 56’ 50.50” | 48° 24’ 20.40” |

## *БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН*

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиад,Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын А/618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам", Монгол Улсын MNS 4628:2013 стандартыг үндэслэл болгон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг гаргалаа.

Байгаль орчны менежементийн төлөвлөгөө нь байгаль орчинд халгүй сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр байх талаар авч хэрэгжүүлж болох арга хэмжээний үндсэн чиглэл болно. Дэлхий нийтээрээ цаг уурын дулаарал, цэвэр усны нөөцийн хомсдол, хөрсний цөлжилт асуудал болоод байгаа энэ үед бид уг стандартыг нэвтрүүлэн ажиллаж байгаа нь байгаль орчин эх дэлхийгээ хамгаалахад оруулж чадах бидний хувь нэмэр юм.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежементийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны алба хянаж, батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль

орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байна.

Тухайн жилийн байгаль орчны менежементийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд тухайн жилийн байгаль орчны менежементийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын 4 дүгээр хэсгийг баримтлан жил бүр шинэчлэн боловсруулна.

ISO 14001 стандартын гол шаардлага нь: Байгалийн нөөц баялгийг хамгийн зохистой үр ашигтайгаар ашиглах, алдалгдлыг бууруулах, байгаль орчныг бохирдуулахаас сэргийлэх, бохирдлыг бууруулах эх үүсвэр дээр нь багасгах замаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд оршдог.

Байгаль орчны талаар баримтлах зорилгот ажлууд:

1. Хөрсний бохирдлыг бууруулах
2. Агаарын бохирдлыг бууруулах
3. Хог хаягдлыг менежментийг сайжруулах
4. Эрчим хүчний хэрэглээг хэмнэх

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 14-р зүйлд заасны дагуу “Форсголд Майнинг” ХХК бүрэн хариуцна.

Төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

| № | Үзүүлэлт | Гүйцэтгэх хугацаа | Төсөвлөсөн нийт дүн/мян.төг/ | Зарцуулсан нийт / мян төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний | 2025 он | 10800 | 10800 |
| 2 | Нөхөн сэргээлтийн ажлын | 2025 он | 5000 | 5000 |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах | 2025 он | 5000 | 5000 |
| 4 | Осол эрсдлийн менежмент | 2025 он | 1000 | 1000 |
| 5 | Хог хаягдлын менежмент | 2025 он | 2100 | 2100 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 2025 он | 3300 | 3300 |
| 7 | Удирдлага зохион байгуулалтын зардал | 2025 он | 5000 | 5000 |
| | Нийт зардал | 2025 он | 32200 | 32200 |

Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын гүйцэтгэл/ хүснэгт 7/

| **Гол ба болзошгүй сөрөг нөлөө** | **Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ** | |
|---|---|---|
| Агаар орчин | | |
| Орчны тоосжилт үүсэх | Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах | Уурхайн бүсд тоосжилт үүсэхээс сэргийлж зуны ид дулаарлын үед өглөө,оройд бусал үед шөнө зам талбайг услах ажлыг хийж ирсэн ба зам талбай услах ажилд нийт 841+ тн ус ашигласан. Мөн тоосжилт бага гаргах зорилгоор уурхайн гол замаас гадна өөр урсгалын зам гаргахгүй байхаар кемпийн дотоод журманд тусган мөрдөн ажиллаж байна. |
| Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл | Байгаль цаг уурын аюулт үзэгдэл болохоос өмнө цаг агаарын урьдчилсан мэдээг Завхан аймгийн УЦУОШГазраас авч үйл ажиллагаандаа ашиглах | Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тухай бүрт авч уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байна.Мэдээг Цаг агаар,мн сайтаас долоо хоног бүр авч ашиглаж байна. |
| Агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах | Уурхайн үйл ажиллагаанаас агаарт тархах тоосны хэмжээг багасгах, салхиар дамжин суурьшлын бүс рүү тархахаас сэргийлж ашиглалт хийгдэж дууссан талбайн техникийн | Техникийн нөхөн сэргээлтийг 9,4 га-д хийх төлөвлөгөөтэй бөгөөд ашиглалт явагдсан 9.4.га-д стандартын дагуу бүрэн хийж дуусгалаа. |

| | | |
|---|---|---|
| | нөхөн  сэргээлтийг бүрэн хийх | |
| | Овоолгын хөрсийг чийгшүүлж шимт байдлыг алдагдуулахгүй байх | Овоолгын хөрсний чийгшлийг Завхан аймгийн УЦУОШГазарт өгч шинжлүүлж чийгшлийн хувийг хянаж ажиллаж байна. |
| Усны нөөц,чанар | | |
| Ус ашиглалтын хяналтын дүн мэдээг жил бүр усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, ус ашиглах дүгнэлтийг жил бүр шинэчлэх | | Ус ашиглалтын хяналтын дүн мэдээг  Монгол улсын хэрэгжүүлэгч агентлаг Усны Газраас боломжит нөөцийн дүгнэлт гаргуулан  үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. |
| Ус ашигласны төлбөрийг төлөх | | 2025 оны ус ашигласны төлбөр тооцоог барагдуулсан болно. |
| Ус бохирдуулсны төлбөр төлөх | | 2025 оны  жилийн ус бохирдуулснытөлбөрийг тооцоолон барагдуулсан. |
| Тунгаах нуурын усанд хяналт тавьж ажиллах. | | Тунгаах нуурын усанд хяналт тавих ажлын хүрээнд доорхи ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.<br>• Тунгаах нуурын уснаас дээж авч Завхан аймгийн УЦУОШГазарт шинжлүүлж нуурын усны хүнд металлын шинжилгээ хийлгэсэн<br>• Далангын тогтвортой байдал нэвчилтэнд дотоод хяналт орж хашаажуулах ажлыг зохион байгуулсан.<br>• Нөөц далан,хаялгын сувгын бэлэн байдалд тогтмол хяналт хийх |

| | | |
|---|---|---|
| | | • Ургамал амьтны амьдрах орчинд нөлөөлж буйд дотоод хяналт шалгалт хийх зэрэг ажлуудыг хийж ирсэн. |
| Уст цэгийн хяналт | | Уст цэгийн хяналтыг уурхайн эзэмшлийн 3 худагт 7 хоног бүр тогтмол хяналтыг хийж бүртгэлжүүлж ажилласан. |
| Уурхайн эзэмшлийн 3 худгаас дээж авч шинжлүүлэх | | Уурхайн эзэмшлийн 3 худгаас дээжийг аймгийн УЦУОШГазарт хүргүүлж шинжлүүлсэн болно.Шинжилгээгээр урд жилүүдийн дундаж байна. |
| Газрын доорх усны хяналт шалгалтын мониторингийн цооног гаргуулах, зөвшөөрөл авах | | Газрын доорхи усны хяналт тавих мониторингийн цооног гаргах зөвшөөрлийг Завхан аймгийн Байгаль орчны газраас авч цооног гарган хяналт тавьж байна. |
| Ундны усанд анхаарч стандартын шаардлагад нийцүүлэх, дээжлэлт хийж лабораторт шинжлүүлэх | | Ундны усыг Ургамал сумын ундны усны худгаас авч зөөвөрлөлт хийж ашиглаж байна.Мөн ундны усны бохирдлоос хамгаалж зориулалтын усны автомашин ашиглан усыг авч байгаа бөгөөд 7 хоногт 1 удаа халдваргүйжүүлж байна.Мөн Завхан аймгийн УЦУОШГазарт дээжийг хүргүүлсэн. |
| Ундны ус хадгалах зориулалтын усан сантай байх. /Ундны усанд хяналт хийх стандартын шаардлагад нийцсэн ус ашиглах | | Ундны ус хадгалах зориулалтын усны машин байршуулан богино хугацаанд хэрэглээг зохицуулан ундны усаар хангаж байна. |
| Хөрс ургамлын бүрхэвч | | |
| Газрын гадарга,газрын хэвлий эвдэгдэх,дор | “Цагаан толгой” уурхайн талбайд аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл олгох,шимт болон | Газар хөндөх зөвшөөрөл олгох журмыг батлуулан 3 талбайд зөвшөөрөл дотооддоо баталсан журмын дагуу хийж бүртгэл хөтөлсөн. |

| | | |
|---|---|---|
| ойтох,нөлөөл өлд өртөх | шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, хуулсан шимт хөрсийг тухайн талбайг нөхөн сэргээхэд буцааж ашиглах,ашиглахгүй тохиолдолд шимт хөрсний овоолгод зориулалтын дагуу хадгалах | |
| Хөрсний чанар доройтох | Хөрсний шинжилгээний дүнгээр стандартаас давсан агууламж илэрвэл, давтан дээж авч баталгаажуулах ба дахин илэрвэл тухайн газрын хөрсийг хуулж гадаад овоолгын талбайд хаях | Хөрсний дээжийг Завхан аймгийн УЦУОШГазарт өгч дээжийг цахим дата баазаар хянаж ажиллаж хөрсний чанар доройтохоос хамгаалж ажиллаж байна. |
| Хөрсөнд бохирдол үүсэх | Хогийн сав, хогийн цэгийн орчинд ариутгал, халдваргүйтгэлийг хийх | Хогийн савыг тусгай талбайд байршуулан ирсэн ба ариутгал халдваргүйтгэлийг 7 хоногт 1 удаа хийж бүртгэлжүүлж ирсэн. |
| | Ариун цэврийн байгууламжийг шинэчлэн байгальд ээлтэй технологи ашиглах | Ариун цэврийн байгууламжийг шинэчлэн 20тн емкос байршуулан түр хадгалалт хийж ажиллаж байна. |
| | Цэвэрлэх байгууламжийг шинэчлэн стандартын шаардлагад нийцүүлэх | Уурхайн кемпийн ариун цэврийн бохирын сувгыг шинэчлэн гал тогоо,угаалгын хэсгийг холбон түр бохир ус байршуулах 20тн сав байршуулан орчны бүсийг халдваргүйжүүлж байна. |

| | | |
|---|---|---|
| | Засварын талбайд асгаралт үүсч хөрсөнд нэвчихээс сэргийлж хатуу хучилттай талбай бий болгох /цементлэх/ | Засварын талбайг машин техник засварлах орчинг бүрдүүлж цементлэсэн. |
| Амьтны аймагт сөргөөр нөлөөлөх | Уурхайн аливаа үйл ажиллагаанаас зэрлэг амьтан эрсдэх, гэмтэх зэргээс хамгаалах арга хэмжээг авах, хяналт хийх | Уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш зэрлэг ан амьтан эрсдсэн тохиолдол байхгүй ба эрсдэхээс хамгаалж зарим хэсэгт хамгаалалтын хашаа хийж эрсдлээс урьдчилан сэргийлсэн. |

Холбогдох зураг






| Байршил /Location/ | Ажлын нэр /Description/ | Байршил /Location/ | Ажлын нэр /Description/ |
|---|---|---|---|
| Засварын хэсэг | Хаягдал тос масло түр хадгалах байр | Засварын талбай кемп хэсэг | Хаягдал тос масло түр хадгалах байр нэвчихээс сэргийлж бүрэн цутгасан |

FORCE GOLD MINING



| Байршил /Location/ | Ажлын нэр /Description/ |
|---|---|
| Засварын хэсэг | Засварын талбайг цементлэсэн байдал |





| Байршил /Location/ | Ажлын нэр /Description/ |
|---|---|
| Засварын талбай  кемп хэсэг | Халдваргүйжүүлэлт |

FORCE GOLD MINING

Холбогдох бичиг баримт

## “Форс голд майнинг”ХХК-ийн “Цагаан толгой “алтны шороон орд ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР

### УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 06 -р сарын 27 -ны өдөр

Дугаар Е-2506-000269

**1.Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:**

Байгууллагын нэр: Форс голд майнинг ХХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 6088759
Захирал: Даваанoров Ганбаатар
Холбоо барих утасны дугаар: 88115777

**2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:**

Байгууллагын нэр: Дойтын булаг ХХК
Холбоо барих утасны дугаар: 80622694

**3. Төслийн нэр, байршил:**

Төслийн нэр: "Цагаан толгой" нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
Байршил: Завхан, Ургамал, 1-р баг, Тосгуур
Харьяалагдах сав газар: Хяргас нуур, Завхан голын сав газар
Хамаарах салбар: Уул уурхай

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:**

| Дугаар | Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт |
|---|---|
| MV-020628 | АМГТГ-аас Завхан аймгийн Ургамал сумын "Од" нэртэй газарт 1,639.24 га талбайд ашигт малтмал ашиглалтын MV-020628 дугаартай тусгай зөвшөөрлийг "Форс голд майнинг" ХХК-д 2016.09.20-ны өдөр олгосон. |

**5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:**

Төслийн хүчин чадал: Төслөөр хоногт 632.3 м3, жилд 123.9 мян.м3 элс олборлож угаан баяжуулна.
Төслийг хэрэгжүүлэх нийт хугацаа (жил): 3
Ажлын горим: 2 ээлжээр
Жилд ажиллах хоногийн тоо: 196
Жилд ажиллах хүний тоо: 72

**6. Усны нөөц, усны эх үүсвэр:**

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР

### УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот Утас: 265528, 265578

2025 оны 08 -р сарын 21 -ны өдөр

Дугаар Е-2508-000049

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар**

Оноосон нэр: Форс голд майнинг ХХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 6088759
Захирал: Ганбаатар
Холбоо барих дугаар: 88115777
Факс :
И-мэйл хаяг :

**2.Төслийн нэр байршил**

Тослийн нэр: "Цагаан толгой" нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
Байршил: Завхан, Ургамал, 1-р баг, Тосгуур
Харьяалагдах сав газар: Хяргас нуур, Завхан голын сав газар
Хамаарах салбар: Уул уурхай
Төслийн дэлгэрэнгүй: Завхан аймгийн Ургамал сумын нутагт байрладаг "Форст голд майнинг" ХХК-ийн MV-020628 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Цагаан толгой нэртэй" алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл нь Улаанбаатар хотоос баруун хойш 1250 км, Завхан аймгийн төвөөс баруун хойш 226 орчим км, Ургамал сумын төвөөс баруун урагш 27 км-т байрлана. 2025 онд 530.79 мян.м3 хөрс хуулж, 88.29 мян.тнн элс олборлон баяжуулж, 106.64 кг алт гарган авахаар төлөвлөсөн.

**3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр**

Форс голд майнинг

**4. Ажиллах горим, хүчин чадал**

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчдын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 3 | 2 ээлжээр | 196 | 72 | 20 |

**5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ**

### ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2025 оны 2 дугаар сарын 27 -ний өдөр

Дугаар Е-2502-000210

Улаанбаатар хот Утас: 265528, 265578

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

**1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:**

Оноосон нэр: Форс голд майнинг
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 6088759
Захирал: Ганбаатар
Холбоо барих дугаар:: 88115777

**1.2. Төслийн нэр, байршил:**

Төслийн нэр: Цагаан Толгой
Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт:
Байршил: Завхан, Ургамал, 1-р баг, Тосгуур
Дэлгэрэнгүй хаяг: Завхан, Ургамал, 1-р баг, Тосгуур, м плаза 403 тоот
Харьяалагдах сав газар: Хяргас нуур, Завхан голын сав газар

**Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл**

**2.1. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин**

Хаягдал ус нийлүүлэх хэлбэр: Байгальд нийлүүлэх
Нийлүүлж буй хаягдал усны төрөл:
Нэмэлт тайлбар: Баяжуулах үйлдвэрт ашигласан нийт усны 27 хувийг нөхөн сэлбэлтээр, 73 хувийг хаягдлын сангаас эргүүлэн авч ашигладаг. 2024 онд 06 дугаар сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл ажилласан.

**2.2. Хаягдал усны хэмжээ**

| Хаягдал ус нийлүүлэх байгууламж | Хүчин чадал | Хаягдал усны төрөл | Хаягдал ус хаях зайлуулах цэг | Нийлүүлэлт | Цэвэрлэгээний арга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Үнд ахуйн хаягдал ус | 25 м3 ээлэхүүнтэй цооног | [Үнд ахуйн хаягдал ус] | Байгальд нийлүүлэх хүрээлэн буй орчинд (Гадаргын ус, хөрс) | | Цэвэрлэдэггүй | 750 м3/жил |

FORCE GOLD MINING

“Форс голд майнинг”ХХК-ийн “Цагаан толгой “алтны шороон орд ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ПҮРЭВДОРЖ

БАТЛАВ
ФОРС ГОЛД МАЙНИНГ ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ГАНБААТАР

**УС АШИГЛАХ ГЭРЭЭ**

2025 оны 04 сарын 21-ны өдөр Дугаар 01 Завхан аймаг, Улиастай сум

**Нэг. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29.1-д -д заасны дагуу "Хяргас нуур Завхан голын сав газрын захиргааны 2025 оны 04-р сарын 09-ний өдрийн 01 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын 2025 оны 04 дугаар сарын 21-ны өдрийн А/15 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

**Ус ашиглуулагчийг төлөөлж:** Байгаль орчны газрын Усны Усны нөөц ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн Жамьянмядаг овогтой Буянхишиг,

**Ус ашиглагчийг төлөөлж:** Завхан аймгийн Ургамал хотоос баруун хойд зүгт 226 км-т, Ургамал сумын төвөөс баруун урагшаа 27 км-т нутагт орших, 9011622079 улсын бүртгэл, 6088759 регистрийн дугаартай "Форс голд майнинг" ХХК–н ерөнхий геологич Дандар овогтой Содном нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл**

**2.1. Ус ашиглах зориулалт:** Ажиллагсдын унд ахуй болон үйлдвэрлэлийн технологи, ногоон байгууламж, зам талбайн тоосжилт, биологийн нөхөн сэргээлтэнд ашиглана. Нийт 7856 $м^3$ ус ашиглахаар 2025 оны усны хэмжээг тооцлоо.

**2.2. Ашиглах усны хэмжээ:**
Нийт усны хэмжээ: 7856 $м^3$/жил

| | |
|---|---|
| 2.2.1 Технологийн ус | 6000 $м^3$ |
| 2.2.2 Унд ахуйн хэрэгцээ | 96 $м^3$ |
| 2.2.3 Зам талбайн тоосжилт дарах | 480 $м^3$ |
| 2.2.4 Нөхөн сэргээлт | 1280 $м^3$ |

**2.3. Усны чанар, найрлага**: Уурхайн ашиглалтын хугацаанд усны чанарын шинжилгээг улирал бүр хийлгэж, дүнг улирал бүр -Байгаль орчны газарт ирүүлэх

БАТЛАВ.
ХЯРГАС НУУР - ЗАВХАН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
З.ЗОЛ-ОД

БАТЛАВ.
ФОРС ГОЛД МАЙНИНГ ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ГАНБААТАР

**УС АШИГЛАХ ГЭРЭЭ**

2025 оны 08 сарын 21-ний өдөр Дугаар 05 Завхан аймаг, Улиастай сум

**Нэг. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29.1-д заасны дагуу Усны газрын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Е-2508-000049 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/16 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Хяргас нуур – Завхан голын сав газрын захиргааны усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн, ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Цэвээндорж овогтой Отгонбилэг,

Ус ашиглагчийг төлөөлж: Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 7-р хороолол, Шинэ дэлхий телевизийн байр 803 тоотод байрлах Форс Голд Майнинг ХХК (Улсын бүртгэлийн дугаар 9011622079, Регистрийн дугаар 6088759)–ийн ерөнхий геологич Дандар овогтой Содном ус ашиглах талаар тохиролцож 2025 оны 12 дугаар сарын 31-н хүртэлх хугацаатайгаар байгуулав.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл**

**2.1. Ус ашиглах зориулалт:** Ажиллагсдын унд ахуй болон үйлдвэрлэлийн технологи, ногоон байгууламж нөхөн сэргээлт, зам талбайн тоосжилт, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглана.

**2.2. Ашиглах усны хэмжээ:**
Нийт усны хэмжээ: 103,501.2 $м^3$/жил

| | |
|---|---|
| 2.2.1 Технологийн ус | 95,353.20 $м^3$ |
| 2.2.2 Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 2160.00 $м^3$ |
| 2.2.3 Зам талбайн тоосжилт дарах | 3,540.00 $м^3$ |
| 2.2.4 Тэрбум мод усалгаа | 24.00 $м^3$ |
| 2.2.5 Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 2424.00 $м^3$ |

БАТЛАВ.
Завхан аймгийн Ургамал сумын
Засаг Дарга
............Гэрэлт-Од

БАТЛАВ.
"Форс Голд Майнинг" ХХК
"Цагаан толгой" төслийн менежер
..................Д.Содном

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 05 сарын 16-ний өдөр Дугаар 1 Ургамал сум

**Нэг. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д -д заасны дагуу Завхан аймгийн Байгаль Орчны Газрын гаргасан 2025 оны 04 сарын 25-ний өдрийн 01 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж хяналт тавихаар Завхан аймгийн Ургамал сумын Тосгуур багийн Засаг дарга Мөнхдалай Наранмөнх.

Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 9-хороо шинэ дэлхий телевизийн байр 803тоот утас :88106854 9011622079 улсын бүртгэл,тоот гэрчилгээтэй, 6088759 регистрийн дугаартай "Форс голд майнинг"ХХК-ны Геологич ЙК94112912 регистрийн дугаартай Дандар овогтой Содном нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2025-12-31-ний өдөр хүргэлх хугацаатайгаар байгуулав.

1.1 **Төслийн нэр байршил:**

Завхан аймгийн Ургамал сумын Тосгуур багт орших MV-020628 тоот"Баруун цагаан толгой" алтны шороон ордны Биологийн нөхөн сэргээлт,ажилчдын ахуйн хэрэглээд. Хяргас нуур-Завхан голын сав газар хамаарна.

1.2. **Төсөл хэрэгжүүлэгч:**

"Форс голд майнинг"ХХК Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 9-хороо шинэ дэлхий телевизийн байр 803тоот

1.3. **Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат:**

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020628

Нийт талбай 1639,24 га

Координат:

1. 93°59'50" 48°24'20,4"
2. 93°59'39,3" 48°21'37,3"
3. 93°56'30" 48°23'30"
4. 93°56'50,5" 48°24'20,4"

FORCE GOLD MINING

# “Форс голд майнинг”ХХК-ийн “Цагаан толгой “алтны шороон орд ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ХЯРГАС НУУР-ЗАВХАН ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

2025 оны 08 сарын 21 өдөр Дугаар А/16 Улиастай

Ус ашиглах зөвшөөрөл
олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29.1 дэх хэсэг, Усны газрын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Е-2508-000049 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. Завхан аймгийн Ургамал суманд орших MV-020628 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Форс Голд Майнинг” ХХК-нд 2025 онд ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 2160.0 $м^3$/жил, технологийн хэрэгцээнд 95353.20 $м^3$/жил, зам талбайн тоосжилт дарахад 3,540.0 $м^3$/жил, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарихад 24.0 $м^3$/жил, ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглахад 2424.0 $м^3$/жил, ус ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. “Форс Голд Майнинг” ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулахыг усны барилга байгууламж, үйлдвэр хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн /Ц.Отгонбилэг/-д даалгасугай.

3. Дараах арга хэмжээг авч ажиллахыг ус ашиглагч “Форс Голд Майнанг” ХХК-ний гүйцэтгэх захирал /Д.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3.1 Ахуйн бохир усыг “Хаягдал ус, Ерөнхий шаардлага” MNS4943:2015 стандартын шаардлагад нийцүүлэн байгальд нийлүүлэх;

3.2 Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах;

3.3 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ын хэрэгжилтийг хангах;

3.4 Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийг хэрэгжүүлж, ус ашиглалтын тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнаж байх;

4.Энэхүү тушаал болон ус ашиглах гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтэн /Т.Даваажаргал/-д даалгасугай.

ДАРГА Э. ЗОЛ-ОД

ТТБ5953 д. 3498271

D:\doc\Tushaal\2025.docx

---

ЗАВХАН АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 17 өдөр Дугаар А/14 Улиастай

Гүний худаг өрөмдөх
зөвшөөрөл олгох тухай

“Усны тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.6,27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.26 дах заалт, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.3 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Завхан аймгийн Ургамал сумын нутаг Тосгуур багт Од нэртэй газарт одоо ашиглаж байгаа 3-н худгаас 50м ойролцоо радиуст N48º25'51.1176" E93º58'22,764" цэгт ашиглалтын худгийн усны түвшинг хянах зорилгоор хяналтын цооног өрөмдөж гаргахыг зөвшөөрсүгэй.

2.Худгийг мэргэжлийн байгууллагаар технологийн дагуу гаргуулан, шавхалтын журнал хөтөлж өрөмдмөл худгийн техникийн паспортын анхны бичилтийг бүрэн, зөв бичилт хийж Байгаль орчны газраар баталгаажуулж “Усны тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахыг “Форс голд майнинг” ХХК-ны дарга Д.Ганбаатарт үүрэг болгосугай.

3.Худгийг мэдээллийн санд бүртгэж, хяналт тавьж ажиллахыг усны нөөц ашиглалт, хамгаалалт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Ж.Буянхишиг, Ургамал сумын Тосгуур багийн засаг дарга нарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ПҮРЭВДОРЖ

ШТА1695 0924100016 9039597

Tushaal 2025

---

ЗАВХАН АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 21 өдөр Дугаар А/15 Улиастай

Ус ашиглуулах зөвшөөрөл
олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29 дүгээр зүйлийн 29.1, Хяргас нуур Завхан голын сав газрын захиргааны 2025 оны 04 сарын 18-ны өдрийн 01 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Завхан аймгийн Ургамал хотоос баруун хойд зүгт 226 км-т, Ургамал сумын төвөөс баруун урагшаа 27 км-т нутагт орших, 9011622079 улсын бүртгэл, 6088759 регистрийн дугаартай “Форс голд майнинг” ХХК-д унд ахуйн хэрэгцээнд 96 $м^3$, нийт технологийн хэрэгцээнд 7856 $м^3$ ус ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2.“Форс голд майнинг” ХХК -тай ус ашиглах гэрээ байгуулж, эрхийн бичиг олгохыг Усны нөөц ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн /Ж.Буянхишиг/-д даалгасугай.

3.Дараах арга хэмжээг авч ажиллахыг ус ашиглагч “Форс голд майнинг” ХХК” ХХК-д /Д.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3.1.Ус ашиглуулах зөвшөөрөлд заасан хэмжээнээс усыг хэтрүүлэн ашиглахгүй байх;

3.2. Цооногийн мэдээллийг улирал бүр ирүүлэх

3.3. Шинжилгээний дүнг улирал бүр ирүүлэх

3.4 Гэрээний дагуу төлбөр төлөх

3.5 Усны тухай хуулийн 28.18, 7.5-ыг ажилдаа хэвшил болгон ажиллах

4.Энэхүү тушаал болон ус ашиглах гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /Ж.Буянхишиг/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ПҮРЭВДОРЖ

ШТА1695 0924100016 9039597

Tushaal 2025

FORCE GOLD MINING





MASM СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 164755

.......................................................-д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXLG загварын 63.0 м³/ц хэмжих хязгаартай, ф80 мм-ийн голчтой № 2310059960 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 019 лацаар битүүмжилж (доогуур зурах)

2026 оны 06 -р сарын 07 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 000002 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2024 оны 06 -р сарын 07 -ны өдөр

MASM СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 268130

.......................................................
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXLG-80 загварын 63 м³/ц хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 25020121178 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 018 лацаар битүүмжилж (доогуур зурах)

2027 оны 08 -р сарын 18 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 000002 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2025 оны 08 -р сарын 18 -ны өдөр

MASM СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 167318

force gold maining -д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXLC-80 загварын 40 м³/ц хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 2023041191 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 014 лацаар битүүмжилж (доогуур зурах)

2026 оны 05 -р сарын 27 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 005338 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2024 оны 05 -р сарын 27 -ны өдөр

MASM СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 167317

force gold maining
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXLG-80 загварын 40 м³ хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 303099587 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 014 лацаар битүүмжилж (доогуур зурах)

2026 оны 05 -р сарын 27 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 007539 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2024 оны 05 -р сарын 27 -ны өдөр

FORCE GOLD MINING










*Ус ашиглалт эхлэхээс өмнө Хяргас нуур завхан голын сав газрын захиргаанаас ажлын хэсэг ирж хөндлөнгийн хяналт шалгалтын ажил зохион байгуулсан.*





2025 оны 5-р сарын 16-ны өдрөөс эхлэн Хүнгий голоос гадаргын ус авч эхэлсэн бөгөөд дүгнэлтэнд заасны дагуу өдөрт 149тн хүртэлх ус ашиглах гэрээтэй ба гэрээний хүрээнд 10-р сарын 8-ны өдөр хүртэл усаа авч ажилласан.





2025 оны 10-р сарын 8-ны өдрөөс голоос ус авахаа зогсоосон бөгөөд ус авч байсан хэсгийн орчны цэвэрлэгээг хийж зам талбайг засаж сайжруулсан.

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /Хүснэгт 8/

| Нөхөн сэргээлтийн зорилго | Нөхөн сэргээх арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт |
|---|---|---|
| Техникийн нөхөн сэргээлт | Гадаад овоолгын талбайд хэлбэржүүлэлт хийх | Гадаад овоолгын талбайд шимт хөрсийг хадгалах стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. |
| | Дотоод овоолгын талбайд хэлбэржүүлэлт хийх | Дотоод овоолгыг мөрдөгдөж буй стандартын дагуу га талбайд хийж ажилласан. |
| | Техникийн нөхөн сэргээлт хийж дууссан биологийн нөхөн сэргээлт | Техникийн нөхөн сэргээлт хийж дууссан 2,5 га-д биологийн нөхөн сэргээлтийг хийсэн.Нөхөн сэргээлтийг эхний жилийн явц 85 хувьтай бөгөөд 2 дахь жилийн ургалт 70 хувиас буулгахгүй зорилгоор өвөлжилтөнд бууц ашиглан дулаалсан. |



Байршил /Location/
Засварын хэсэг

Ажлын нэр /Description/
Техникийн нөхөн сэргээлт










Байршил /Location/
Засварын талбай кемп хэсэг

Ажлын нэр /Description/
Биологийн нөхөн сэргээлт





2025 оны ашиглалтын үед өмнөх онуудад нөхөн сэргээлт дутуу хийгдсэн болон 2025 онд олборлолт хийгдэж буй талбайнуудад дотоод дүүргэлтийн аргаар нөхөн сэргээлтийг хийж байна.











Өмнөх онуудад ашиглалтанд өртсөн талбай болон 2025 онд ашиглалт хийгдсэн талбайнуудад техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж таних тэмдэг самбар байрлуулсан.







2025 онд ашиглалтын талбайд нийт 5 га талбайг биологийн нөхөн сэргээлтэнд бэлтгэн хашаалж шимт хөрс хучих, усалгаа хийх зэргээр нөхөн сэргээлтэнд бэлтгэн хавар, зун, намрын улирлуудад олон настын үр тариалсан.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ /Хүснэгт 9/

| Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зорилт,хамгаалах арга хэмжээ | Хийсэн ажил |
|---|---|
| Дүйцүүлэн хамгаалах талбай болон уурхай орчмын ургамал,амьтны мониторинг судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх | Уурхайн орчмын ургамал амьтны судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.Мөн уурхайн үйл ажиллагааны явцын үед ургамал болон амьтны судалгааг үйл ажиллагаа явагдаж буй улиралд хийж ирсэн. |
| Зэрлэг амьтны амьдрах орчныг тэтгэх зорилгоор хөв цөөрөм байгуулах | Уурхайн орчимд зэрлэг ан амьтан нутаглахгүй байгаа учир хөв цөөрөм хийгээгүй |
| Биологи, техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгөх | Биологийн нөхөн сэргээлтийг 2.5 га-д ерхөг,мандал сорт,хошоонго,царгас,хүцэнгэ,судан, овъёос тариалсан ба ургалт 85 хувьтай байна.Мөн зам талбайг нэгтгэн нэг урсгалтай болгосноор хөрсний эвдрэлийг багасгаж өөрийн хөрсний үндсэн ургамал ургах орчинг бий болгож ажиллаа.Мөн кемпийн талбайн 10 хувьд ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор тариалалтыг хийсэн. |
| Улиастай сумын Чигэстэй голын дагуу барьсан хашаа,хайс хамгаалалтын тохижилт,өнгө үзэмжийг сайжруулах, байнгын харуул манаачтай байлгах,хуваарилагдсан модны тодорхой хэсгийг энэ байршилд тарих,усалгаа арчилгааг тогтмол хийж ургуулах,амьдралтын хувь 75 -иас дээш байлгах | Улиастай сумын Чигэстэй голын дагуу барьсан хашаа,хайс хамгаалалтын тохижилт,өнгө үзэмжийг сайжруулах, байнгын харуул манаачтай байлгах,хуваарилагдсан модны тодорхой хэсгийг энэ байршилд тарих,усалгаа арчилгааг тогтмол хийж байна. |



FORCE GOLD MINING

